

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ  
АХУЙН НЭГЖИЙН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	4
	2.1. Оршил .....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
	2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
	2.11. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
	2.12. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал .....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
	4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан .....	15
	4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан .....	16
	4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
	4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	19
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ СОЛОНГОСЫН ДОРНЫН  
АНАГААХ УХААНЫ ТӨВИЙН ЗАХИРАЛ  
Л.ЖАМБАЛЖАВ ТАНАА

2019.03.14 № 06/430  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төв нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

---

### **2.1. Оршил**

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төв 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн захирал Л.Жамбалжав Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг СТОУС(НББОУС) болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 2-ноос 2019 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Эс Жи Эм Ди Аудит ХХК-ийн аудитын баг аудитыг хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2018 оны санхүүгийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС(НББОУС), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, сургалт, судалгаа явуулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Эрүүл мэндийн сайдын тушаалаар Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дорнын анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлэх, сургалт судалгаа явуулах

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрүүл мэндийн тухай

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус төвийн санхүүгийн үйл ажиллагаа нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй бөгөөд энэ нь байгууллагын статус тодорхойгүй байгаатай холбоотой байна.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ “Microsoft Excel” програм хангамж ашигладаг байна.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгов.

Энэ нь материаллаг байдлын суурийг нийт зардлын дүнгээс тооцоход их байгаа тул нийт хөрөнгийг суурь үзүүлэлт болгон сонгосонтой холбоотой юм.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2018 нийт хөрөнгө 89.7 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 0.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал  
(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	128.2	
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>128.2</b>	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй байна.

## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Эдэлбэр газар болон барилгын доорх газрын асуудалыг 2019 онд багтаан яаралтай шийдвэрлэх

## **2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид “зорилтын санал” гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 2.4 “санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг” гэж заасны дагуу зорилтын саналыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад байгууллагын удирдлага нь энэ хуулийн 21<sup>1</sup> дүгээр зүйлийн 7-р заалтыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын удирдлага нь батлагдсан төлөвлөгөөний төсөв, гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 465.3 сая төгрөгийн төлөвлөгөөний төсөв батлагджээ.

Нийт зардлын гүйцэтгэл 336.3 сая төгрөг буюу 72.2 хувьтай байгаа нь орлогын гүйцэтгэлээс шалтгаалжээ.

## **2.11. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.12. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг

холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал**

##### **1.1 Илрүүлэлт:**

Тус байгууллага нь төрийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газрын статусаар үйл ажиллагаагаа явуулж байна. Улсын төсвөөс санхүүжилт авдаггүй өөрсдийн эмчилгээ үйлчилгээний орлогоор санхүүждэг. Ажилчин албан хаагчид нь төрийн үйлчилгээний албан хаагчдын шатлалаар цалинждаг нь байгууллагын статус болон хууль эрх зүйн орчин тодорхойгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.1 гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

##### **1.2 Эрсдэл:**

- Үнэн зөв байх батламж мэдэгдэл хэрэгжихгүй байх
- Ажилчин, албан хаагчдын эрх ашиг хохирох
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

#### *1.3 Өгсөн зөвлөмж:*

Байгууллагын статус, хариуцлагын хэлбэр, харьяаллыг тодорхой болгох арга хэмжээг авч ажиллах зөвлөмж хүргүүллээ.

#### *1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

Байгууллагын статус, харьяаллын асуудлыг эрх бүхий байгууллагуудад удаа дараа хандсан боловч шийдвэрлэгдээгүй.

### **2. Балансын данстай холбоотой асуудал**

#### *2.1 Илрүүлэлт:*

Тус төвийн барилга нь Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын тусламжаар 2001 онд баригдсан бөгөөд Эрүүл Мэндийн яамны үндсэн хөрөнгөнд бүртгэгдсэн.

Энэ нь оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 дахь, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

#### *2.2 Эрсдэл:*

- Үндсэн хөрөнгө өөрийн эзэмшилд байхгүй
- Байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

#### *2.3 Өгсөн зөвлөмж:*

Тус төвийн барилгыг холбогдох байгууллагаар шийдвэр гаргуулан өөрийн өмчлөлд шилжүүлэн байгууллагын хөрөнгөнд бүртгэж авах, төрийн болон орон нутгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 “хуульд заасан бусад төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө” заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүллээ.

#### *2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

Төвийн барилгыг Эрүүл мэндийн яамны баланс бүртгэлтэй байгааг төвийн нэр дээр авах асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

### **3. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал**

#### *3.1 Илрүүлэлт:*

Байгууллагын үйл ажиллагаа явуулж байгаа эдэлбэр болон байшингийн доорх газар нь тус байгууллагын эзэмшилд байхгүй, газрын гэрээ, гэрчилгээ байхгүй, кадастрын зураглал хийлгээгүй, газрыг хөрөнгөнд тусгаагүй, бусад этгээдтэй газрын маргаантай байна

Энэ нь оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль, Газрын тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

### **3.2 Эрсдэл:**

- Газар эзэмшлийн асуудал тодорхойгүй
- Байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах

### **3.3 Өгсөн зөвлөмж:**

Тус төвийн барилгын доорх газрын асуудлыг газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах”, 4.1.7 “газар дээрх үл хөдлөх хөрөнгө нь тухайн газрын бүрдэл хэсэг байх” гэсэн заалтын дагуу шийдвэрлэн өөрийн байгууллагын хөрөнгөнд бүртгэж авч, ажиллах зөвлөмж хүргүүлээ.

### **3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Газрын асуудал шийдэгдээгүй байна. Эрүүл Мэндийн Яамны коллегийн хурлаар 2018 оны 10 дугаар сард хэлэлцэж шүүхэд нэхэмжлэл гаргахыг даалгасан.

## **4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал**

### **4.1 Илрүүлэлт:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй

Энэ нь илчлэл ба толилуулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

### **4.2 Эрсдэл:**

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх
- Санхүүгийн тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байх

### **4.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9, 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.2.2 заалтын дагуу шинэчлэгдсэн хууль, журам, СТОУС /НББОУС/-ийн

өөрчлөлтүүдийг бүрэн тусгуулан боловсруулж, баталж дагаж мөрдөн ажиллах зөвлөмж хүргүүлээ.

#### *4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

Мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авч Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болно. Хүлээн зөвшөөрч байна.

### **5. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал**

#### *5.1 Илрүүлэлт:*

Өмчийн дүнг санхүүгийн тайланд болон улсын бүртгэлийн гэрчилгээнд зөрүүтэй бүртгэсэн

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

#### *5.2 Эрсдэл:*

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх
- Санхүүгийн тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байх

#### *5.3 Өгсөн зөвлөмж:*

Санхүүгийн тайлангийн эздийн өмч (төрийн өмч) -ийн дүн болон Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүнг санхүүгийн тайлантай нийцүүлэх, зөрүүг арилгаж зөв болгож бүртгэж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

#### *5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

2013 онд эздийн өмчийг шинэчлэн бүртгүүлсэн. Түүнээс хойш бүртгэлд өөрчлөлт ороогүй. Хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 1-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2018	12/31/2018
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,623,841.05	2,980,382.80
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	500,000.00	0.0
1.1.6	Бараа материал	3,139,489.00	2,045,258.00
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>5,263,330.05</b>	<b>5,025,640.80</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	54,475,371.97	80,673,330.97
1.2.2	Биет бус хөрөнгө	0.0	4,000,000.00
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>54,475,371.97</b>	<b>84,673,330.97</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>59,738,702.02</b>	<b>89,698,971.77</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг		30,000,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг		0.0
2.1.1.3	Татварын өр	4,917,614.31	1,960,108.84
2.1.1.4	НДШ–ийн өглөг	5,748,510.34	0.0
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>10,666,124.65</b>	<b>31,960,108.84</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>10,666,124.65</b>	<b>31,960,108.84</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	60,387,091.00	60,387,091.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	3,252,387.00	3,252,387.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	67,930,200.00	67,930,200.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(82,497,100.63)	(73,830,815.07)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>49,072,577.37</b>	<b>57,738,862.93</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>59,738,702.02</b>	<b>89,698,971.77</b>



## 4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	332,723,340.00	356,123,100.00
2	Борлуулалтын өртөг		
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>332,723,340.00</b>	<b>356,123,100.00</b>
8	Бусад орлого	2,387,000.00	210,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	339,192,466.32	349,424,664.86
12	Бусад зардал	2,601,924.04	
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(2,369.26)	
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	80,000.00	
17	Бусад ашиг ( алдагдал)	723,800.00	
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(7,325,481.76)</b>	<b>6,908,435.14</b>
19	Орлогын татварын зардал		690,843.51
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(7,325,481.76)</b>	<b>6,217,591.62</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(7,325,481.76)</b>	<b>6,217,591.62</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(7,325,481.76)</b>	<b>6,217,591.62</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1 2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	60,387,091.00	3,252,387.00	67,930,200.00	(82,497,100.63)	49,072,577.37
2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3 Залруулсан үлдэгдэл	60,387,091.00	3,252,387.00	67,930,200.00	(59,970,614.75)	71,599,063.25
4 Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)					
5 Бусад дэлгэрэнгүй орлого					
6 Өмчид гарсан өөрчлөлт					
7 Зарласан ногдол ашиг					
8 Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9 2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	60,387,091.00	3,252,387.00	67,930,200.00	(82,497,100.63)	49,072,577.37
0 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				2,448,693.94	2,448,693.94
1 Залруулсан үлдэгдэл	60,387,091.00	3,252,387.00	67,930,200.00	(80,048,406.69)	51,521,271.31
2 Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				6,217,591.62	6,217,591.62
3 Бусад дэлгэрэнгүй орлого					

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

4	Өмчид гарсан өөрчлөлт					
5	Зарласан ногдол ашиг					
6	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
7	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	60,387,091.00	3,252,387.00	67,930,200.00	(73,830,815.06)	57,738,662.94

#### 4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>332,457,001.31</b>	<b>354,453,290.00</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	331,995,498.00	353,898,911.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	461,503.31	554,379.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>329,707,847.01</b>	<b>343,096,748.25</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	142,046,368.00	131,092,566.80
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	38,500,000.00	41,631,124.45
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	74,281,745.00	67,133,013.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	29,280,206.00	49,168,898.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	11,891,237.00	19,149,195.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	14,263,900.00	15,000,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	19,444,391.01	19,921,951.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>2,749,154.30</b>	<b>11,356,541.75</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>80,000.00</b>	
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	80,000.00	
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,037,410.00</b>	<b>10,000,000.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,037,410.00	10,000,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,957,410.00)</b>	<b>(10,000,000.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(208,255.70)</b>	<b>1,356,541.75</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,832,096.75</b>	<b>1,623,841.05</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,623,841.05</b>	<b>2,980,382.80</b>

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

**Аудитын нэр:**

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

**Огноо:**

2019.03.15

**Аудитын код:**

САГ-2019/4/СТА-ТБООААН

**Шалгагдсан байгууллагын нэр:**

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төв

**Мянган төгрөгөөр:**

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (мян.төг)	Гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	Тус төвийн эдэлбэр газар болон барилгын доорх газрын асуудлыг шийдвэрлээгүй		Зөвлөмж өгөх	Захирал	Лхамсүрэн Жамбалжав
2	Тус төвийн үндсэн хөрөнгө болох барилга нь Эрүүл мэндийн яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй.	105,613.4	Зөвлөмж өгөх	Захирал	Лхамсүрэн Жамбалжав
3	НББ-ын баримт бичиг байхгүй		Зөвлөмж өгөх	Захирал	Лхамсүрэн Жамбалжав
4	Өмчийн дүнг санхүүгийн тайланд болонд улсын бүртгэлийн гэрчилгээнд зөрүүтэй бүртгэсэн	22,579.2	Зөвлөмж өгөх	Захирал	Лхамсүрэн Жамбалжав
5	Байгууллагын статус тодорхойгүй		Зөвлөмж өгөх	Захирал	Лхамсүрэн Жамбалжав
	<b>Дүн</b>	<b>128,192.6</b>			